



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/72

Булган сум

Албан томилолтоор ажиллуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XI/03 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр”, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.2.2.3 заалт, “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн О.Сайнзаяа, Г.Дэлгэрмаа, С.Цэдэнлхам, Г.Буянзаяа нарыг БНХАУ-д Нягтлан бодох бүртгэлийн олон улсын хуралд оролцох, туршлага судлах ажлаар албан томилолтоор ажиллуулсугай.

2. Албан томилолтоор ажиллахад шаардагдах зардал 18,000,000 (Арван найман сая) төгрөгийг Засаг даргын хуулиар олгогдсон зарим чиг үүргийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

3. Туршлага судалсан ажлын илтгэх хуудас, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010107